



СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Д.УРАНТОГОС

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН 11 ДУГЭЭР АНГИАС АВАХ
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

“А” ХУВИЛБАР

Хугацаа: 60 минут

Нийт: 40 оноо

Анги : Сурагчийн нэр :

Арван долоотой байхад

Манайх Цээлд, Бөөдэйнх Улаандэлд зусч байлаа. Цээлийн тойром нуурлачихсанаас хойш тэдний адуу, тэмээ усны үнэрээр цуван ирэх болж бид хоёрын уулзаж байхад ганц сайн шалтаг болсон юм.

Бөөдэй ээжтэйгээ хоёулхнаа суудаг болохоор тэмээ малдаа өөрөө л явна. Хааяа унаагаа юүлүүлэх гэж адуугаа тууж ирэхэд нь би уургынхаа хээрийг барьж мордоод хорь хүрэхгүй адууг нь хураан хөндөлсүүлж явсаар барих морио тэгэхээс тэгж адуунаас нь гарган элдээд сүүл дэрлэн дагах хэвтээ дэмтэй сайхан хээрийнхээ дөрөө зуран эргэх яг л тэр агшинд

бөхийн цацаж, сүүлэндээ салхи татуулан зугатаах морины нарийн хоншоороор уургалан эргүүлээд, үргэн давхисан адууныхаа хойноос янцгаан тэмүүлэх түүнийг эмнэг уургалсан мэт

цухалзуураар нь эрж Бөөдэйг хүлээж зогсоно. Бөөдэй үсрэн бууж олмоо тавиад, эмээлээ өргөн, мориныхоо нурууг нар харвахаас болгоомжлон салхи оруулж хэсэг сүүдэрлэн зогссоноо хазаараа мулталж инээсээр ирнэ. Энэ бол миний арван долоон насанд хамгийн жаргалтай мөч байлаа. Гэвч энэ маань өглөөдөө үзэгдэх хөвчийн манан шиг байжээ.

Чойдогийн хүү цэргээс иржээ, нутаг усны айлуудаар бууж явна гэсэн сураг уснаас ус

дамжин, саахалтын бүсгүйчүүд хонинд явахдаа ч гоёж гоодох болов. Би ч түүнийг үзэхийн хүслэн болж байтал ашгүй нэг ирлээ. Тэрбээр аавынхаа төхөөрч тавьсан бэсрэг хэрэгсэлтэй

боржгон эмээл тохож, шанхалж дэллэсэн өндөр шарга морь унажээ. Нэрийг нь Ойдов гэнэ. Хараар гурав эмжсэн саарал даавуу дээл хөөргөн өмсөж бор бүрх малгай сагалдаргалаад шажигнасан чимээтэй хороомон гутал өмссөн нь гоёлын дээд бөгөөд өргөн ханхар мөр, тэгш

цагаан шүд, шооч байрын хүрэн нүд нь ер сумандаа л би гэж хэлээд байх шиг санагдана.

Ойдовынх бас Улаандэлд, түүнийг манайхаар буугаад мордсоноос хойш Бөөдэйн адтуу тэмээ нууранд ирэхээ больчихов. Нэг өдөр айлын адуунд байсан даагатай гүү авчрах далимаар Улаандэл орж хэргээр орой болгоод Бөөдэйн адтууг бэлчээрээс нь хөөн Цээлийн нууранд авчирчихаад маргааш нь Бөөдэйг ирнэ гэж нуурын баруун овоон дээр харуулдан

суутал Ойдов хархүү алаг морьтой давхиж ирээд хөөгөөд явчихлаа. Тэдний мал уттал нууранд ирээгүй учрыг би сая л нэг гадарлаж чичигнэн инээдэг хөөрхөн Бөөдэйг минь хулгайлан хөөгөөд явчихаж байгаа юм шиг хойноос нь уттал ширтэн зогсохдоо Ойдовын эрдэм чадал, сайн сайханд хязгааргүй атаархаж байгаагаа мэдэв. Ойдовын энэ сайхан бүхэн цэрэгт алба хаасны л ач гэж өөрөө өөртөө батлаад, наасаа нэмж байгаад ч хамаагүй энэ жил л цэрэгт явчихъя гэж хатуу шийдэж билээ. Тэгээд сумын наадам дээр Ойдовыг хаячхаад урт түрүүтэй хороомон гутлаа шажигнуулан дэлж Бөөдэйн хажуугаар харалгүй өнгөрнө дөө гэж бодоход сэтгэлийн тээг сэмрэн, ярс ярс алхлан яваа цэрэг эрчүүдийн жагсаалд орчихсон юм шиг хөгжилтэй сэргэлэн болов оо.

1. “Би” баатрын дурд дүгнэлт хийнэ үү. /4 оноо/

“Би” баатрын үйлдлээс 2-3 –ыг сонгон дүгнээрэй.

.....
.....
.....
.....
.....

2. “Сэтгэлийн тээг сэмрэн” гэсэн холбоо үгтэй ойролцоо утгатай хэлцийг олоорой. /4 оноо/

.....
.....
.....
.....
.....

3. Тодруулсан хэсгээс гадаад орчин ба би баатрын дотоод сэтгэл хөдлөлийн өнгө аясыг олж бичнэ үү. /4 оноо/

.....
.....
.....
.....
.....

4. Эхийн уншигчдад үзүүлэх нөлөөллийг жишээгээр батална уу. /2 оноо/

.....
.....
.....
.....

5. Эхэд юуны тухай өгүүлсэн бэ? / 2 оноо/

- a) Цэргийн алба b) Арван долоон нас
c) Аз жаргал d) Анхны хайр e) Сумын наадам

6. Намар сэдэвт “Хайку” шүлэг зохион бичнэ үү? /5 оноо/

.....
.....
.....

7. "Махабхарата" тууль хэдэн жилийн түүхтэй вэ? Хэдэн ботиос бүтсэн бэ? /2 оноо/


.....
.....
.....

8. “Игорийн хорооны үг” зохиолын гол санааг 2 өгүүлбэрт багтаан бичээрэй. /2 оноо/

.....
.....
.....
.....

9. Монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлнэ үү. /5 оноо/

10. “Залуу нас” сэдвээр эх зохион бичихдээ өөрийн үзэл бодолтой холбон, олон талаас нь эргэцүүлэн баримт, тайлбар ашиглан, орон цаг, нөхцөл байдлыг дүрслэн, мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн бичээрэй. Үгийн тоо 150-180 /10 оноо/





СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Д.УРАНТОГОС

**ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН ДУГЭЭР АНГИАС АВАХ
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

“Б” ХУВИЛБАР

Хугацаа: 60 минут

Нийт: 40 оноо

Анги :

Сурагчийн нэр :

Аавын үг, хүүгийн үйлс

Цагийн хүүхэд төдийгүй, цаг яван одоход бодлоо үлдээж чадсан цагийг бүтээгч хөвгүүдийн нэгэн Лодон агсны хүү Түдэвийн тухай өнгөрснийг дурдатгал, эдүгээгийн бясалгалаар тодосгон байж энэхүү хөрөг нийтлэлийг бичсүү хэмээн зориглов.

Лодон гуай эргэж ирэхгүй аянд мордохоосоо хэдэн сарын өмнө “Би Чингисийн эр хоёр загал шиг хоёр хүүтэй явлаа. Багыг маань харийн орны Мушгия голын лусын дагина тэвэрч аваад буцааж өгсөнгүй. Тавилан гэдэг энэ биз. Энэ Түдэв л одоо хоёр хүний хийхийг нэгэн биеэр үүрч, хоёр загалын явахыг нэгэн загалын хөлөөр туулах болжээ...” гэснийг нэхэн санав.

Ингээд аавын үг, хүүгийн үйлс хоёр найрсан жигдэрч, эцгийн юу санасан есөн хүслийн манлай нь ёсоор бүтсэн сэн.

...Түдэв ажлын үеэр зохиол бичнэ гэж ер үгүй, зөвхөн оногдсон оногдсонд нь шууд хамаарах ажлаа л хийнэ. Хурдан, хальт мөлт болчих вий дээ гэмээр тун хурдан бичнэ. Баллана, сохолно гэж бараг үгүй. Үзэг нь дэгдэн гүйж, хар бэхийн нэг мөр нөгөө мөрөө дэрлэн ундрах нь горхи горхины бидэргээ адил хөвөрнө. Үүнд ер бусын хувилгаан чанар байхгүй ч ширээгдэж төрсөн номч мэргэнд заяадаг чанар буй. Үзэг нь бүдэрнэ ээ гэж үгүй.

Хэд хэдэн салбарын хэдэн зуун ном туурвиж, гuchaад хэлээр нэг сая таван түмэн ширхэгээр хэвлүүлсэн бичгийн хүний үзэг уяа нь таарсан хүлэг адил тийм ч байхаас яахан аж гэж бодогдоно.

**1.Хүүгээ дүрсэлсэн аавын үгэнд хүүгийн ямар зан чанарыг тодруулсан бэ?
Жишээгээр тайлбарлан бичнэ үү. /4 оноо/**

2. “Үзэг ньадил хөвөрнө” өгүүлбэрт ямар дүрслэх ур маягийг ашигласан байгааг тайлбарлаад, утга ойролцоо үгсээр солин найруулна уу? /4оноо\

3. Хүүгийн ажил үйлсээр нь түүний гадаад болон дотоод мөн чанарыг тус бүрд нь 4-ээс доошгүй холбоо үгээр илэрхийлэн бичнэ үү? /4 оноо\

4. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийг угсруулан холбох нөхцөлөөр солин найруулж бичнэ үү. /2 оноо/

Хэд хэдэн салбарын хэдэн зуун ном түүрвиж, гучад хэлээр нэг сая таван түмэн ширхээр хэвлүүлсэн бичгийн хүний үзэг уяа нь таарсан хүлэг адил...

5. Эхийн хэсгийг уншаад юуг ойлгосон бэ? Баатрын ямар шинжийг чанарыг өөртөө хэрэгжүүлмээр санагдаж байна вэ? /2 оноо/

6. Үүлэн зардас найраглалын гол санааг 40-50 үгэнд багтаан бичээрэй. /5 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

7. Нарангэрэл дагинь түүж зохиолоос юу ойлгож авсан бэ? Өөрийн бодлоо бичээрэй. /2 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

8. “Хамелеон” өгүүллэгээс ямар сургамжит олж авсан бэ? Та нар ямар зан чанарыг эрхэмлэдэг вэ? /2 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

9. Монгол бичгээс кирилл бичигт буулгаж бичнэ үү. /5 оноо/

Jækøj0 Fojøbb.
fokilej0 Nikt
KibKa Jia firøsa I foyekba Nekt
Næø0 blyea
feldøft kij0 Nis0 NiBS0 Blj0 bñiesea
KibKa Jia
Høygola Næø0 blyea O kf* D0 KirbB,

10. “Эдийн ашиг эхэнд, эрдмийн ашиг эцэстээ” сэдвээр 120- 150 угэнд багтаан эх зохион бичээрэй. /10 оноо/

Өөрийн үзэл бодолтой холбон олон талаас нь эргэцүүлэн бичихдээ баримт мэдээлэл болон дурслэх ур маягийг зохицтой ашиглан, өөрийн үзэл бодлоор эргэцүүлэн бичээрэй.

